



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 76

Улаанбаатар хот

Хорооны 2012 оны 248 дугаар тогтоолоор
батлагдсан журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2 дахь заалтыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 8 дугаар сарын 08-ны өдрийн 248 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагаас гаргах хаалттай өрийн бичгийг бүртгэх журам”-д доор дурьдсан агуулгатай дараах 2 дугаар зүйлийн 2.9, 4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсгийг тус тус нэмсүгэй:

1/ 2 дугаар зүйлийн 2.9 дэх хэсэг:

“2.9 ББСБ нь арилжаалсан хаалттай өрийн бичгийн хүчин төгөлдөр хугацаанд өрийн бичиг нэмж гаргаж болох ба Хороо нэмж гаргах өрийн бичгийг энэ журмын 2.1-2.8-д заасан шаардлага, 3.1-д заасан баримт бичгийн бүрдлийг хангасан тохиолдолд бүртгэнэ”;

2/ 4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсэг:

“4.4. ББСБ нь хаалттай өрийн бичгийг гэрээнд заасан хугацаанд бүрэн төлж барагдуулаагүй бол уг гэрээний үүргийн гүйцэтгэлийг бүрэн хангасан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд тухайн ББСБ-ын өрийн бичиг гаргах хүсэлтийг Хороо дахин хүлээн авахгүй”;

2. Мөн журмын 2 дугаар зүйлийн 2.2, 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийг доор дурьдсанаар өөрчлөн найруулсугай.

1/ 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэг:

“2.2. ББСБ-аас гаргах хаалттай өрийн бичиг нь 12 сар хүртэлх хугацаатай байх ба өрийн бичгийг худалдсан өдрөөс эхлэн хугацааг тооцно”.

2/3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэг:

“3.2 ББСБ нь Хорооноос хаалттай өрийн бичгийг бүртгэх тухай шийдвэр гарсан өдрөөс хойш 6 сарын дотор шийдвэрт заасан хэмжээгээр өрийн бичгийг арилжаалах бөгөөд уг хугацаанд арилжаалагдаагүй өрийн бичгийг хүчингүй болсонд тооцно”.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН



000070